



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ**

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар A/166

Улаанбаатар хот

**Г Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрлөөр олгосон эрх хасах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Зөрчлийн тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн 2.3 дах хэсэг, Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны 2 дугаар сарын 05-ны 0063635 дугаартай шийтгэлийн хуудас, 2020 оны 2 дугаар сарын 13-ны 03/68 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний их эмч Даваарагчийн Нармандахын ИЭТ0009594 сери, 0009594 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс 3 сарын хугацаагаар хассуугай.
2. Д.Нармандахын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрх хассантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай:
  - 2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг гурван сарын хугацаагаар хассан тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;
  - 2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хассан талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Яаралтай тусламж судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Л.Ганболд/, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар /Ц.Мөнхцэцэг/, Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Жигдэнгомбо/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвлөлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.



Д.САРАНГЭРЭЛ

141200577